



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/229

Ховд

Дэд ажлын хэсэг шинэчлэн
байгуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 157 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алсын хараа-2050” урт хугацааны бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх хүрээнд хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хангах, Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуй нэгжийг дэмжих цогц арга хэмжээний санал боловсруулах, ажлын хэсэгт өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх үүрэг бүхий дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсын Ерөнхий сайдын өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх, Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуй нэгжийг дэмжих арга хэмжээний санал боловсруулах ажлыг хугацаанд нь шуурхай зохион байгуулж, үр дүнг ажлын хэсэгт тухай бүр нь тайлагнан ажиллахыг дэд ажлын хэсгийн ахлагч (Л.Энхбаяр)-д үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан “Дэд ажлын хэсэг байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/184 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА

8400091 0677

Zah A/229 Och

Аймгийн Засаг даргын 2025 оны
04 дүгээр сарын 07-ны өдрийн
А/229 дүгээр захирамжийн хавсралт



Дэд ажлын хэсгийн
ахлагч:

Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн
дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,
төрийн сангийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх
зүйн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт
шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн дарга

Цэргийн штабын дарга

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын дарга

Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга

Соёл урлагийн газрын дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын
дарга

Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын
дарга

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Улсын бүртгэлийн газрын дарга

“Цахилгаан түгээх сүлжээ” ХХК-ийн дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Монгол Улсын Их Сургуулийн Ховд аймаг дахь
салбар сургуулийн захирал

Хөгжил политехник коллежийн захирал

Статистикийн хэлтсийн дарга

Татварын хэлтсийн дарга

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга

Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга

Шинэ Ховд ОНӨААТҮГ-ын дарга

Сумдын Засаг дарга нар

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл
мэдээллийн ажилтан

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн Үйлчилгээний
нэгдсэн төв хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,
эрх зүйн хэлтсийн Авто тээврийн хяналтын
улсын ахлах байцаагч

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн Сум,
байгууллагын асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн Гадаад
харилцааны асуудал хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн Төлөвлөлт,
зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр,
нийгмийн хамгаалал, гэр бүл, хүүхэд
залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, эдийн засаг, бодлого зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Үйлдвэр, худалдаа үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

-oOo-